



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 456

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан нийт 59,900,000.00 /тавин есөн сая есөн зуун мянган/ төгрөгийн балансын үнэ, 43,498,809.48 /дөчин гурван сая дөрвөн зуун ерэн найман мянга найман зуун есөн төгрөг дөчин найман мөнгө/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт /Шадар сайдын ажлын албанд/ балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа удирдлагын алба, “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн
456 дугаар тогтоолын хавсралт



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн
газарт балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан теана, 07-24 УБЗ	2019	59,900,000.00	43,498,809.48	16,401,190.52
	Нийт дүн		59,900,000.00 /тавин есөн сая есөн зуун мянган/	43,498,809.48 /дөчин гурван сая дөрвөн зуун ерэн найман мянга найман зуун есөн төгрөг дөчин найман мөнгө/	16,401,190.52 /арван зургаан сая дөрвөн зуун нэг мянга нэг зуун ерэн төгрөг тавин хоёр мөнгө/